



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/295


Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/264 дүгээр тушаалын 1 дэх заалтын жил бүрийн 8 дугаар сарыг Эрүүл мэндийн ажилтны "Нийгмийн баталгаа"-г хангах сар гэснийг "Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар" болгон өөрчилсүгэй.
2. Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/264 дүгээр тушаалд нэмэлт оруулж "Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар"-ыг жил бүр зохион байгуулах ерөнхий удирдамжийг нэгдүгээр, 2018 оны 8 дугаар сард хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. "Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар"-ын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд оруулах, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар(Б.Баярт)-т үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081242

**“Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар”-ыг
жил бүр зохион байгуулах ерөнхий удирдамж**

Зорилго:

Эрүүл мэндийн хүний нөөцийн бодлого, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлд бүх түвшний эрүүл мэндийн байгууллагын оролцоо, санаачлагыг идэвхижүүлэх, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулахад “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар”-ын зорилго оршино.

Зорилт:

1. Эрүүл мэндийн хүний нөөцийн бодлого, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах
2. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг тогтмолжуулж, тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлэх
3. Эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулах, ажлын байрны дэмжлэгт орчин бүрдүүлэх замаар ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах

Зайлшгүй хамрах арга хэмжээний чиглэл:

1. Эрүүл, аюулгүй ажлын байр бүхий дэмжлэгт орчин бүрдүүлэх
2. Эрүүл мэндийн ажилтны эрүүл мэндийг дэмжих
3. Эрүүл мэндийн ажилтан, байгууллагын нэгж, хамт олонд мөнгөн болон мөнгөн бус урамшуулал олгох
4. Байгууллага, шилдэг ажилтан, нэгж, хамт олны үйл ажиллагааг байгууллага, орон нутаг, улсын хэмжээнд сурталчлах
5. Эрүүл мэндийн ажилтны мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх гадаад, дотоод сургалтыг зохион байгуулах
6. Эрүүл мэндийн ажилтны гэр бүлийг дэмжих

Холбогдох бусад арга хэмжээг байгууллага өөрийн түвшиндээ нэмэлтээр тодорхойлж болно.

Хамрах хүрээ:

1) Бүх шатлалын эрүүл мэндийн байгууллага энэхүү удирдамжийг баримтлан “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар”-ыг жил бүрийн 8 дугаар сард зохион байгуулна.

2) Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар”-ыг харьяа нутаг, дэвсгэрийн нийт эрүүл мэндийн байгууллагыг хамруулан зохион байгуулна.

3) Түүнчлэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд энэхүү удирдамжийг жишиг болгон өөрийн байгууллагын ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих үйл ажиллагаанд хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Зарчим:

1. Эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, түүний харьяа эрүүл мэндийн байгууллагууд жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар”-ыг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааг тусгана.

2. Шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар”-ын хүрээнд тухайн жилд илүүтэй анхаарах үйл ажиллагааны чиглэлийг хүргүүлнэ.

3. Эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүргүүлсэн чиглэлээс гадна өөрийн байгууллагын хамт олны санал хүсэлт, бусад эрүүл мэндийн байгууллагад хэрэгжүүлсэн сайн туршлагад тулгуурлан “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар”-д хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжүүлнэ.

4. Эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, тэдгээрийн харьяа байгууллага өөрийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ байгууллагын санхүүгийн эх үүсвэрээс гадна орон нутгийн засаг захиргааны байгууллага, Олон улсын байгууллага, нийгмийн хариуцлагатай бизнесийн байгууллага, төрийн бус байгууллагын дэмжлэг оролцоонд тулгуурлана. Энэ чиглэлд байгууллагын удирдах ажилтан онцгойлон идэвхи санаачлагатай ажиллана.

5. “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар”-ын хүрээнд эрүүл мэндийн байгууллага нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Мэргэжлийн хяналтын байгууллага, стандартын байгууллага, анагаах ухааны боловсрол олгох сургууль, хэвлэл, мэдээллийн байгууллага, бусад оролцогч талуудтай хамтран ажиллана.

6. “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар”-ын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар жил бүрийн 9 дүгээр сард багтаан хамт олондоо ил тод тайлагнадаг байна.

7. “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар”-ын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд хамруулан үнэлнэ.



Эрүүл мэндийн сайдын
2018 оны 07 сарын 20 өдрийн
А.А.А. дугаар тушаалын 2 дугаар хавсралт

“ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ ДЭМЖИХ САР”-ЫН ХҮРЭЭНД
2018 ОНЫ 8 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

№	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хүрэх үр дүн
1.	Эрүүл мэндийн байгууллага бүр ажилтнуудаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар Эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллага	Урьдчилан сэргийлэх үзлэгт орсон эрүүл мэндийн ажилтны тоо	Сардаа	Эрүүл мэндийн ажилтнуудын өвчлөл буурна.
2.	Шинээр ажилд орсон болон өмнө жил элэгний В, С вирусын халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдаагүй эрүүл мэндийн ажилтнуудыг шинжилгээнд хамруулах	Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар Эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллага	Элэгний В, С вирусын халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	Сардаа	Эрүүл мэндийн ажилтнуудын өвчлөл буурна.
3.	Эрүүл мэндийн ажилтнуудыг элэгний В вирусын эсрэг дархлаажуулалтад үнэ төлбөргүй хамруулах эрх зүйн орчныг судлан шийдвэрлэх, хэрэгжүүлэх	ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн газар Халдварт өвчин судлалын үндэсний төв Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар Эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллага	Дархлаажуулалтанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	Сардаа	Эрүүл мэндийн ажилтнуудыг ажлын байрны эрсдлийн улмаас элэгний В вирусын халдвар авахаас сэргийлнэ.
4.	Элэгний С вирусын халдвар илэрсэн эрүүл мэндийн ажилтнуудыг үнэ төлбөргүй эмчилгээнд хамруулах	ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн газар Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар	Эмчилгээнд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	Сардаа	Эрүүл мэндийн ажилтнуудын өвчлөл буурна.

№	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хүрэх үр дүн
		Эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллага			
5.	Эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэх үзлэгийг хөнгөлөлттэй үнээр хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг шийдвэрлэх	ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв	Холбогдох шийдвэр гарсан байна.	VIII/06-17	Эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлт сайжирна.
6.	Эрүүл мэндийн ажилтны төрсөн аав, ээж, ах, дүү, нөхөр, хүүхдэд өөрийн байгууллагын түвшинд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх боломжийг судлан, байгууллагын дотоод журамд тусгах	Эрүүл мэндийн байгууллагууд	Хөнгөлөлттэй үйлчлүүлсэн эрүүл мэндийн ажилтны төрсөн аав, ээж, ах, дүү, нөхөр, хүүхдийн тоо	Сардаа	ЭМСайдын 2010 оны 224 дүгээр тушаалын хэрэгжилт хангагдана.
7.	Эрүүл мэндийн салбарын оны шилдгүүдийг шалгаруулах, эрүүл мэндийн сайдын нэрэмжит оюутны тэтгэлэг олгох ёслолын арга хэмжээг зохион байгуулах	ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар Эдийн засаг санхүүгийн хэлтэс Эрүүл мэндийн хөгжлийн төв	Эрүүл мэндийн салбарын оны шилдгүүдийг шалгаруулах, эрүүл мэндийн сайдын нэрэмжит оюутны тэтгэлэг олгох ёслолын арга хэмжээ зохион байгуулагдсан байна.	VIII/06-10	Эрүүл мэндийн ажилтнуудын сэтгэл ханамж сайжирна.
8.	Эрүүл мэндийн ажилтан, нэгж хамт олны үйл ажиллагааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар ЭМЯ-ны Олон нийттэй харилцах, тандалт, шуурхай удирдлагын хэлтэс Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар Эрүүл мэндийн яамны харьяа	Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан эрүүл мэндийн ажилтан, нэгж хамт олны талаарх нэвтрүүлгийн тоо	Сардаа	Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт сайжирна.

№	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хүрэх үр дүн
		эрүүл мэндийн байгууллага			
9.	Эрүүл мэндийн байгууллагуудын сул ажлын байрыг нөхөх зорилгоор хөдөлмөрийн яармагийг зохион байгуулах	Эрүүл мэндийн хөгжлийн төв Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар Эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллага	Шинээр ажилд орсон эрүүл мэндийн ажилтны тоо	VIII/09-20	Эрүүл мэндийн байгууллагын сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулж авах боломж бүрдэнэ.
10.	Эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллага, дүүргийн нэгдсэн эмнэлгийн хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнүүдэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар 2 хоногийн сургалт зохион байгуулах	ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн газар Эрүүл мэндийн хөгжлийн төв Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулагдсан байна.	VIII/25-31	Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдлын хангах ажиллагааны төлөвлөлт сайжирна.
11.	ЭМХТ-өөс хийгдсэн орон сууцны судалгааг эцэслэн БХБЯ-нд санал хүргүүлэх	ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар Эрүүл мэндийн хөгжлийн төв Ажлын хэсэг	Эрүүл мэндийн ажилтны орон сууцны зээлтэй холбоотой тодорхой саналыг БХБЯ-нд хүргүүлсэн байна.	VIII/25-31	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгаалал сайжирна.
12.	Байгууллагын ажилтнуудын санал хүсэлтэд тулгуурлан нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр эрүүл мэндийн байгууллага бүр 1-2 шинэлэг арга хэмжээг санаачлан хэрэгжүүлэх	Эрүүл мэндийн байгууллагууд	Эрүүл мэндийн байгууллагуудад туршлага болох шинэлэг арга хэмжээний тоо	Сардаа	Эрүүл мэндийн ажилтнуудын сэтгэл ханамж сайжирна.